



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 571

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 16 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны ХБ-111-12/1378 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, ерөнхий захирлын 2019 оны А/1057, А/1058, А/1059, А/1060 дугаартай Контракт дүгнэх тухай тушаалын дагуу үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 4 ширхэг, 644,637,450.00 (зургаан зуун дөчин дөрвөн сая зургаан зуун гучин долоон мянга дөрвөн зуун тавин төгрөг 00 мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 643,837,593.00 (Зургаан зуун дөчин гурван сая найман зуун гучин долоон мянга таван зуун ерэн гурван төгрөг 00 мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан эд хөрөнгийг данснаас хасах ажлыг үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001322



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн
58 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Тоёота Ландкрузер 200, 82-88 УНУ, арлын дугаар JTMHV05J04114946	30.11.2013	199,964,300.00	199,164,443.00	799,857.00
2	Тоёота Ландкрузер 200, 65-08 УБХ, арлын дугаар JTMHX05J304022826	31.01.2013	150,000,000.00	150,000,000.00	-
3	Тоёота Ландкрузер 200, 00-10 УБГ, арлын дугаар JTMHX05J204050021	31.10.2013	194,673,150.00	194,673,150.00	-
4	Ниссан Патрол, 45-24 ОРО, арлын дугаар JN1TANY62Z0010173	30.04.2012	100,000,000.00	100,000,000.00	-
Нийт дүн			644,637,450.00 (зургаан зуун дөчин дөрвөн сая зургаан зуун гучин долоон мянга дөрвөн зуун тавин төгрөг)	643,837,593.00 (зургаан зуун дөчин гурван сая найман зуун гучин долоон мянга таван зуун ерэн гурван төгрөг)	799,857.00 (долоон зуун ерэн есөн мянга найман зуун тавин долоон төгрөг)